



ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГА Г.ӨЛЗИЙБҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013-04-09 № 01/53

Г Авлагын тооцоо нийлж баталгаажуулах тухай

Газрын тосны газрын 2012 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар газрын тосны орлогын төлөөгүй үлдэгдэл 11182.3, төлөөлөгчийн болон сургалтын үйл ажиллагааг дэмжих хөрөнгө, бусад орлогын төлөөгүй үлдэгдэл 1522.2, нийт 12704.5 сая төгрөгийг 2012 оны санхүүгийн тайланд авлага үүсгэсэн дансны бичилт бичихдээ тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй болох нь тогтоогдоо.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн "19 дүгээр зүйлийн 19.1.4-т "...тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрзэний биелэлтийг үнэн зөв гаргах.." гэсэн заалт зөрчигдсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ыг үндэслэн ШААРДАХ Нь:

1. Гэрээлэгч нартай тооцоо нийлсэн акт үйлдэж харилцан баталгаажуулсны үндсэн дээр газрын тосны орлого, төлөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих хөрөнгө, сургалтыг дэмжих хөрөнгө, бусад орлогын үлдэгдлийг тайлан балансад авлагаар тусгаж байх,
2. Алан шаардлагын хэрэгжилтийг 2013 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Газрын тосны газрын Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нямдорж, ерөнхий нягтлан бодогч С.Оюун наарт хариуцуулан албан шаардлага хүргүүлэв.

АЛБАН ШААРДЛАГА ХҮРГҮҮЛСЭН

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР



Ц.ГЭРЭЛ

07.156